

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ИЛТГЭХ ХУУДАС

Дүүргийн Засаг дарга, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан
2025 оны хариуцлагын гэрээний жилийн эцсийн биелэлт, Засаг даргын Тамгын газрын
2025 оны гүйцэтгэлийн тайланд хяналт шинжилгээ хийсэн тухай

2025 оны 12 сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээний гол зорилго нь Дүүргийн Засаг дарга, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан хариуцлагын гэрээ болон Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт, зорилт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт болон тайлангийн хүрсэн түвшинг бодитой тооцож, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэх, биелэлтэд үнэлгээ өгөх, гарсан алдаа, дутагдлыг арилгах, биелэлтийг журмын дагуу хуулийн хугацаанд үнэн зөв чанартай тайлагнуулахад чиглэнэ.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

Дүүргийн Засаг даргын хариуцлагын гэрээний 2 бүлэг 10 зорилт, 109 арга хэмжээ, Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн тайлангийн 3 бүлэг, 61 зорилт, 122 арга хэмжээний хэрэгжилтийг Засаг даргын Тамгын газрын хэлтэс тус бүрээр нэгтгэн хяналт шинжилгээ хийлээ.

Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний бүтэц;

№	Агуулга	Зорилго	Зорилт	Арга хэмжээ
1	Төрийн албаны зохион байгуулалт-20 минутын хотын шилжилт	3	16	33
2	Эко дүүрэг-Ногоон хөгжил	9	31	56
3	Дэд бүтэц-Хот нийтийн аж ахуй	3	13	14
4	Хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд	1	1	22
НИЙТ ДҮН		16	61	122

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны хариуцлагын гэрээний бүтэц;

Бүлэг	хэмжээ	Зорилт, арга	
		Зорилт	Арга хэмжээ
Дүүргийн Засаг даргын эрх, үүрэг		9	104
Нийслэлийн Засаг даргын дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт		1	5
НИЙТ ДҮН		10	109

ГУРАВ. АРГА ЗҮЙ

Засаг даргын 2025 оны Хариуцлагын гэрээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, хийхдээ Засгийн газрын 2025 оны 43 тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Хяналт шинжилгээ хийх журмын 6.1-т заасан хэрэгжиж байгаа бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ хийх аргачлалаар, Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн тайланд тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг дүгнэх журмын 2.4, 2.5-д заасан аргачлаар тооцлоо.

**ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНЭЭС ХЭЛТЭС
АЛБАДЫН ХАРИУЦСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

Хариуцан хэрэгжүүлэх нэгжийн нэр		Гурав.	Дөрөв.
		Дүүргийн Засаг даргын эрх, үүрэг	Нийслэлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Арга хэмжээ	 12	
	Хэрэгжилт (%)	96%	
Санхүү, төрийн сангийн хэлтэс	Арга хэмжээ	 5	1
	Хэрэгжилт (%)	89%	90%
Хууль, эрх зүйн хэлтэс	Арга хэмжээ	 9	
	Хэрэгжилт (%)	100%	
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Арга хэмжээ	 2	
	Хэрэгжилт (%)	100%	
Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс	Арга хэмжээ	 4	4
	Хэрэгжилт (%)	95%	85%
Нийгмийн хөгжлийн хэлтэс	Арга хэмжээ	 27	
	Хэрэгжилт (%)	91%	
Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	Арга хэмжээ	 26	
	Хэрэгжилт (%)	98%	
Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	Арга хэмжээ	 6	
	Хэрэгжилт (%)	100%	
Онцгой байдлын хэлтэс	Арга хэмжээ	 1	
	Хэрэгжилт (%)	100%	
Улсын бүртгэлийн хэлтэс	Арга хэмжээ	 1	
	Хэрэгжилт (%)	100%	
Дотоод аудитын алба	Арга хэмжээ	 2	
	Хэрэгжилт (%)	99%	
Худалдан авах ажиллагааны алба	Арга хэмжээ	 4	
	Хэрэгжилт (%)	100%	
Газар зохион байгуулалтын алба	Арга хэмжээ	 2	
	Хэрэгжилт (%)	100%	
Статистикийн хэлтэс	Арга хэмжээ	 1	
	Хэрэгжилт (%)	100%	
Хан-Уул яармаг ОНӨААТҮГ	Арга хэмжээ	 1	
	Хэрэгжилт (%)	100%	
Нийт хэлтсүүд	Арга хэмжээ	 2	
	Хэрэгжилт (%)	100%	
Нийт арга хэмжээ		109	5
Хэрэгжилтийн дундаж хувь		91.1	86%

**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЭЛТСҮҮДИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТАЙЛАНГИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**


Бүтэц, агуулга	Төрийн албаны зохион байгуулалт-20 минутын хотын	Эко дүүрэг-Ногоон хөгжил	Дэд бүтэц-Хот нийтийн аж ахуй	Хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд	Нийт	Биелэлт	Бүрэн хангалттай (85буюу түүнээс дээш)	Хангалттай (70-85 хүртэл)	Хангалтгүй (70 хүртэл)	Хугацаа болоогүй
Хэлтэс албадын нэр										
Зорилго	3	9	3	1	16					
Зорилт	16	31	13	1	61					
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	12			9	21	99.4%	21			
Санхүү, төрийн сангийн хэлтэс	7				7	94.1%	6	1		
Хууль, эрх зүйн хэлтэс	1	1		2	4	100.0%	4			
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	5			2	7	100.0%	7			
Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс	6	6	11		23	88.0%	16	3	4	
Нийгмийн хөгжлийн хэлтэс		13		3	16	90.8%	13	1	2	
Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	1	13	3	6	23	92.4%	18	3	1	1
Архивын хэлтэс	5				5	89.9%	3	2		
Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	3	7			10	90.0%	8		2	
Цэргийн штаб	6				6	94.7%	6			
Нийт	46	40	14	22	122	93.3%	102	10	9	1

ДӨРӨВ. ҮР ДҮН

Дүүргийн Засаг даргын 2025 оны хариуцлагын гэрээний 2 бүлэг 10 зорилт, 109 арга хэмжээ жилийн эцсийн байдлаар 91,1% үр дүнтэй хэрэгжсэн. Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн тайлангийн 3 бүлэг, 61 зорилт, 122 арга хэмжээний хэрэгжилтийг Засаг даргын Тамгын газрын хэлтэс тус бүрээр нэгтгэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 93,3%, “Бүрэн хангалттай” хэрэгжжээ.

4.1 Дүүргийн Засаг дарга Нийслэлийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хариуцлагын гэрээний жилийн эцсийн хэрэгжилт

№	Зорилт, арга хэмжээ	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй 85%-аас дээш	Үр дүн хүлээгдэж байгаа 60-84	Үр дүн хангалтгүй 30-59	Үр дүн гараагүй 0-29	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	Үнэлгээ /хувь/
	Бүлэг								
1	Дүүргийн Засаг даргын эрх, үүрэг	9	104	97	3	4			96%
2	Нийслэлийн Засаг даргын дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт	1	5	3	1	1			86,3%
НИЙТ ДҮН		10	109	100	4	5			91.1%



Дүүргийн Засаг даргын 2025 оны Хариуцлагын гэрээний жилийн эцсийн хэрэгжилтээс 30 хувьтай хангалтгүй хэрэгжиж буй 1 заалт:

Д/д	Зорилт	Хэрэгжилт (хувь)	Хариуцах нэгж
ГУРАВ. ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ			
57	3.3.23 Багш, удирдах ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах, орон сууцны болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр дэмжлэг үзүүлэх орон нутгийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	-	НХХ, БХ

Засаг даргын 2025 оны Хариуцлагын гэрээнээс жилийн эцсийн байдлаар 50-55 хувь хангалтгүй хэрэгжсэн 4 заалт;

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага
Гурав. Дүүргийн Засаг даргын эрх, үүрэг			
3.1.Хууль тогтоомжийн хүрээнд:			
3	3.1.1.3 25.1.5 Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт;	Орон нутгийн хөгжлийн сангаас шилжүүлсэн орлого 2,005.8 сая төгрөг бөгөөд үүнээс 8 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид 1,833.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон.	СТСХ
59	3.3.25 Дүүрэгт бүртгэлтэй өвлөн уламжлагчдыг дэмжих, урамшуулж, хамтарч ажиллана.	Дүүрэгт бүртгэлтэй 83 өвлөн уламжлагчийн судалгааг шинэчлэн гаргасан. Өвийн боловсролын түгээн дэлгэрүүлэх, өв соёлоосоо суралцах, түүгээрээ бахархах, бусдад үлгэрлэх зорилго бүхий “Өв соёлоо танин мэдь” сургалтыг нийт 5 байгууллагад 11 удаа зохион байгуулж, 212 иргэнийг хамруулсан. Нүүдэлчин дэлхийн соёлын фестивальд Хан-Уул дүүргээс оролцох соёлын өвийн өвлөн уламжлагчдын сонгон шалгаруулалтыг 2025 оны 08 дугаар сарын 11-нд Хан-Уул дүүргийн Соёлын ордонд зохион байгуулж, 70 иргэнийг хамруулсан. “Өв соёлоо танин мэдь” арга хэмжээний хүрээнд Хан-Уул дүүргийн	НХХ, Насан туршийн суралцах төв

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага
		Насан туршихуйн сургалтын төвийн байгууллагын багш, ажилчдын дунд “Алаг мэлхий өрөх” “Алаг мэлхийг 108 шагайгаар хэн хурдан өрөх вэ?” монголын уламжлалт тоглоомыг зохион байгуулж, тус байгууллагын цахим хуудсанд байршуулсан нь 3890 хүнд хүрсэн байна.	
66	3.4.6	Хот нийтийн “Ulaanbaatar Engineering” Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийн нэгдсэн хяналт, удирдлагын цогц системийн үйл ажиллагааг бүрэн нэвтрүүлэн, мэдээллийн сангийн баяжилтыг тогтмол мэдээллээр хангана.	ХСТНААХ
Дөрөв. Нийслэлийн Засаг даргын дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт			
4.1.Дүүргийн Засаг даргаас Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр хүлээх хариуцлага:			
104	4.1.3	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Хан-Уул дүүрэгт 2024-2025 он дамжин санхүүжих 303,000,000 (гурван зуун гурван сая) төгрөгийн 6 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах; Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 321.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөгдсөнөөс 17 дугаар хороонд Хан хиллс хотхоноос Хүннү 2222 хүртэл авто зам хүртэл явган хүний зам талбайн тохижилтын ажил бүрэн хэрэгжиж, 6 төсөл арга хэмжээ гүйцэтгэлийн шатанд он дамжин хэрэгжиж байна. Он дамжин хэрэгжиж байгаа ажлуудыг явц, гүйцэтгэлээр авч үзвэл: 1. Нийтийн ахуй үйлчилгээний төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажил 50 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Гүйцэтгэгч "ГЭЭТ" ХХК 2. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил 90	ТГУХ, СТСХ, ХААА


Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага
		хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Гүйцэтгэгч Бат ахим анжеси ХХК 3. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Гүйцэтгэгч: Эйч Ти Эл ХХК 4. "Чанд авиа" өрхийн эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх ажил 5 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Гүйцэтгэгч Мисс ди ХХК 5. Өрхийн эрүүл мэндийн төвүүд болон нийслэлийн ерөнхий боловсролын 34, 41 дүгээр сургуулийн засварын ажил 64 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Гүйцэтгэгч Өрнөх гэгээ ХХК 6. "Уясах" өрхийн эрүүл мэндийн төвийн Үйлчилгээний хүлээлгийн хэсэг буюу хөтөч сувилагчийн постын тохижилтын ажил 5 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Гүйцэтгэгч Өрнөх гэгээ ХХК.	

4.2 Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

№	Бүлэг	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Бүрэн хангалттай (85буюу түүнээс дээш)	Хангалттай (70-85 хүртэл)	Хангалтгүй (70 хүртэл)	Хугацаа болоогүй	Биелэлт
1	Төрийн албаны зохион байгуулалт-20 минутын хотын шилжилт	3	16	33	29	4			95.8%
2	Эко дүүрэг-Ногоон хөгжил	9	31	53	41	5	6	1	91.3%
3	Дэд бүтэц-Хот нийтийн аж ахуй	3	13	14	10	1	3		85.6%
4	Хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд	1	1	22	22				99.3%

№	Бүлэг	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Бүрэн хангалттай (85буюу түүнээс дээш)	Хангалттай (70-85 хүртэл)	Хангалтгүй (70 хүртэл)	Хугацаа болоогүй	Биелэлт
НИЙТ ДҮН		16	61	122	102	10	9	1	93.3%

Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэл



Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 бүлгийн 15 зорилго, 60 зорилтын хүрээнд 100 арга хэмжээ, хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд 22 арга хэмжээ тусгагдсан. Үүнээс;

Эхний бүлгийн 16 зорилтын хүрээнд 29, хоёр дахь бүлгийн 41, гуравдахь бүлгийн 10, дөрөв дэх бүлгийн 22, нийт 102 арга хэмжээ бүрэн хангалттай хэрэгжсэн. Мөн эхний бүлгийн 4, хоёр дахь бүлгийн 5, гурав дахь бүлгийн 1, нийт 9 арга хэмжээ хангалттай хэрэгжсэн.

Харин хоёр дахь бүлгийн 6, гурав дахь бүлгийн 3, нийт 9 арга хэмжээ хангалтгүй хэрэгжиж, хоёрдугаар бүлгийн 1 арга хэмжээ хугацаа болоогүй байна.

122 арга хэмжээнээс



Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн тайлангаас хангалтгүй хэрэгжсэн 9 арга хэмжээ;

Д/д	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Хариуцах нэгж	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
ДЗДҮАХ-ийн зорилго 2.1. Төсвийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж ил тод нээлттэй байдлыг сайжруулан төсвийн хөрөнгийг үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж хэрэгжүүлнэ.				
Зорилт 18. Хувийн хэвшил, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудын санал санаачилгыг дэмжин тулгамдсан асуудлыг шийдэх үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ 2.1.2)				
44	Арга хэмжээ: 18.3 “Бүтээгч Хан-Уулчууд” дэд хөтөлбөрийн хүрээнд төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, бизнес эрхлэгчдийг дэмжиж ажиллана.	ХХҮХ	“Бүтээгч Хан-Уулчууд” дэд хөтөлбөрийн хүрээнд нийт 4 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж, бизнесийн шинэлэг санаачилга, гарааны бизнес болон үйл ажиллагаагаа өргөжүүлж буй аж ахуйн нэгжүүдийг бодитойгоор дэмжин ажилласан бөгөөд үүний үр дүнд бизнес эрхлэгчдийн оролцоо нэмэгдэж, эдийн засгийн эргэлтэд шинэ ажлын байрууд бий болоход дэмжлэг үзүүлэн ажилласан.	50%
ДЗДҮАХ-ийн зорилго 2.2. Жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжинэ.				

Д/д	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Хариуцах нэгж	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
Зорилт 20. “Хан-Уулд үйлдвэрлэв” борлуулалтын төвийг байгуулж, төвийн үйл ажиллагаагаар дамжуулан гарааны бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллана. (ДЗДҮАХ 2.2.2)				
47	Арга хэмжээ: 20.1 “Хан-Уулд үйлдвэрлэв” бизнес эрхлэгчдийг дэмжих борлуулалтын үйл ажиллагааг зохион байгуулна.	ХХҮХ	“Хан-Уулд үйлдвэрлэв” борлуулалтын төвийг байгуулахтай холбогдуулан 8 аж ахуйн нэгжээс талбайн хэмжээ, үнийн саналыг авч, боловсруулан "Бүтээгч-Хан-Уулчууд" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийн хурлаар танилцуулж, борлуулалтын төвийг байгуулах санхүүжилтийг 2026 оны төсөвт тусгахаар шийдвэрлэсэн.	50%
ДЗДҮАХ-ийн зорилго 2.5. Агаар, хөрс бохирдуулагч эх үүсвэрийг иргэдийн оролцоотойгоор бууруулж, байгальд ээлтэй хэрэглээг нэмэгдүүлнэ.				
Зорилт 35. Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагааны улмаас бохирдсон, доройтсон, эвдэрсэн газар, газрын хэвлийг хоргүйжүүлэх, нөхөн сэргээх, хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, хариуцлагатай үйл ажиллагааг хэвшүүлнэ. (НЗДҮАХ 4.1.2, 4.1.7, ДЗДҮАХ 2.5.5)				
66	Арга хэмжээ: 35.1 Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд тавих хяналт шалгалтыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлнэ.	ХХҮХ	НБОГ-н даргын А/149 дүгээр тушаалаар 2025 оны нөхөн сэргээлтийг хянаж хүлээн авах ажлын хэсэг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл дүүргийн хэмжээнд нөхөн сэргээлтийг хүлээн авахаар бэлтгэл ажил хангаж байна.	50%
ДЗДҮАХ-ийн зорилго 2.7. Хүүхэд бүр чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй эзэмших нөхцөлийг бүрдүүлж, суралцагчийн хөгжлийг бүх талаар дэмжинэ.				
Зорилт 44. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд монгол бичиг, гадаад хэл болон байгалийн ухааны уралдаан тэмцээнүүдийг жил бүр зохион байгуулж, сургалтын чанарыг ахиулахад дэмжлэг үзүүлнэ. (ДЗДҮАХ 2.7.3)				
81	Арга хэмжээ: 44.1 Дүүргийн Засаг даргын нэрэмжит олимпиадыг зохион байгуулж, сурагчдын оролцоог нэмэгдүүлнэ.	НХХ	2025-2026 оны хичээлийн жилд улсын төрөлжсөн олимпиадыг дүүргийн хэмжээнд 12 судлагдахуунаар зохион байгуулсан. Төрөлжсөн олимпиадад тус дүүргийн 3854 сурагч, 361 багш хамрагдсан. (Дүүргийн Засаг даргын нэрэмжит олимпиад төсвийн хязгаарлалттай холбоотойгоор зохион байгуулагдаагүй.)	30%

Д/д	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Хариуцах нэгж	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
ДЗДҮАХ-ийн зорилго 2.9. Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжиж, соёл болон хамгааллын олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.				
Зорилт 46. Өсвөр үе, залуучуудыг сөрөг зан үйл, хорт зуршил, цахим дээрэлхэлтээс ангид байх, хувь хүний хөгжлийг дэмжих сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна. (ДЗДҮАХ 2.9.3)				
83	Арга хэмжээ: 46.1 Өсвөр үе, залуучуудын дунд хорт зуршлаас татгалзах уриалга бүхий видео контентын уралдаан зохион байгуулна.	НХХ	Өсвөр үе, хүүхэд, залуучуудыг сөрөг зан үйл, хорт зуршлаас татгалзах, урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран нийслэлийн ерөнхий боловсролын 10, 15, 26, 41, 59, 60, 75, 114, 115, 118, 130, Монгол-Оюу билэг, Цэлмэг дижитал сургууль зэрэг нийт 15 сургуульд “Тамхины хор уршиг ба дам тамхидалтын талаарх ойлголт”, “Архины хор уршиг”, “Сэтгэл зүйн онцлог” сэдвээр сургалт, нөлөөллийн ажлыг 2025 оны II улиралд зохион байгуулсан. Тус нөлөөллийн үйл ажиллагаанд нийт 11578 сурагчид хамрагдсан байна.	50%
Зорилт 47. Ашиглалтын шаардлага хангахгүй дүүргийн Соёлын ордны барилгыг дахин төлөвлөж соёл, урлагийн арга хэмжээг нэгдсэн байдлаар зохион байгуулах боломжтой барилга, байгууламжийг шинээр барина. (ДЗДҮАХ 2.9.6)				
86	Арга хэмжээ: 47.1 Ашиглалтын шаардлага хангахгүй дүүргийн Соёлын ордны барилгыг буулгаж шинээр барих ажлын зураг төсвийг боловсруулж магадлал хийлгүүлнэ.	ТГУХ	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтын шаардлага хангахгүй Соёлын ордны барилгыг буулгаж, шинээр барих ажлын зураг төсвийн гүйцэтгэгчээр “Ньюкон” ХХК ажиллаж байна. Соёлын ордны барилгын ажлын загвар зураг батлагдаж, холбогдох байгууллагуудаас техникийн нөхцөл хүссэн, ажлын зураг төсөл боловсруулах шатанд 60 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.	60%

Д/д	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Хариуцах нэгж	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
ДЗДҮАХ-ийн зорилго 3.3 Зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөн хүртээмжийг нэмэгдүүлж түгжрэлийг бууруулахад дэмжлэг үзүүлнэ.				
Зорилт 55. Нутаг дэвсгэрийн хөдөлгөөний эрчим их гол гудамж замуудын уулзварыг дахин төлөвлөж нэвтрүүлэх чадварыг сайжруулах ажлыг Улс, нийслэл, дүүргийн төсөв бусад хөрөнгийн эс үүсвэрээр барьж байгуулах ажлыг хамтран хэрэгжүүлнэ. (НЗДҮАХ 1.4.5, ДЗДҮАХ 3.3.1)				
95	Арга хэмжээ: 55.1 Нисэхийн тойргийг олон түвшинт уулзвар болгох ажлын нэгдүгээр үе шатны ажлыг бүрэн дуусгана.	ТГУХ	Авто замын түгжрэлийг бууруулж, гол замын хөдөлгөөний хурдыг нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Нисэхийн тойргийг олон түвшинт уулзвар болгох ажлын нэгдүгээр үе шатны ажил” хэрэгжүүлж байна. Тус ажлын гүйцэтгэгчээр “Туулын гүүр далай” ХХК ажиллаж байгаа бөгөөд, 4 замын уулзвар болгох ажил хийгдэж хөдөлгөөн нээсэн, уулзварын трасст өртсөн дулааны шугам зөөж шилжүүлэх ажил 100 хувь, цэвэр, бохир усны шугам зөөх ажил 100 хувь, цахилгаан, холбооны шугам зөөх ажил 80 хувь, борооны ус зайлуулах шугамын ажил 70 хувь, уулзварын ажлын явц 30 хувьтай байна. 4 замын уулзвар болгох ажлын нөлөөлөлд өртсөн Туурайн төвөргөөн ХХК-ийн газар чөлөөлөх асуудал 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр шийдвэрлэгдсэн бөгөөд 2026 онд авто замын ажил үргэлжилнэ.	60%
Зорилт 57. Нийтийн тээврийн дундын болон эцсийн зогсоолуудыг дулаан зогсоол болон саравч бүхий тохилог орчинтой болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, ая тухтай орчныг бүрдүүлнэ. (НЗДҮАХ 1.5.2, ДЗДҮАХ 3.3.4)				
97	Арга хэмжээ: 57.1 Нийтийн тээврийн 4-өөс доошгүй зогсоолыг шинэчлэн тохижуулж, 2 дулаан буудлыг ашиглалтад оруулна.	ТГУХ	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 9, 10, 14, 21 дүгээр хороонд шинээр 5 байршилд автобусны буудал байгуулах ажлын гүйцэтгэгчээр “Грейдерийн хүч рөүд” ХХК шалгарч, гэрээ	30%

Д/д	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Хариуцах нэгж	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
			байгуулсан. Ажил эхлэх шатанд хэрэгжиж байна. Тус ажлын хүрээнд 9 дүгээр хороонд Нисэхийн шинэ эцэс, 10, 21 дүгээр хороонд Буянт-Ухаа 1 хорооллоос Морингийн даваа хүртэлх зам дагуух 2, 14 дүгээр хороонд МТ ШТС-аас хороо хүртэл зам дагуу 2 автобусны буудлын тохижилт хийгдэхээр төлөвлөгдсөн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр Нанобриллиант констракшн ХХК 11 дүгээр хороонд Зайсангийн эцсийн автобусны буудлын тохижилтыг хэрэгжүүлж, хөдөлгөөн зохион байгуулалтыг шинэчилсэн.	
Зорилт 60. Дугуйн болон явган хүний замын сүлжээг нэмэгдүүлж, шаардлага хангахгүй болсон дугуйн зам, явган замуудыг засварлан шинэчилнэ. (ДЗДҮАХ 3.3.7)				
100	Арга хэмжээ: 60.1 Дугуйн болон явган хүний замыг стандартад нийцүүлэн өргөтгөн шинэчлэх, шинээр явган хүн, дугуйн замын сүлжээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.	ТГУХ	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Чингисийн өргөн чөлөө, Их Монгол улсын гудамжны явган хүний зам талбайг байгалийн боржин чулуун хавтан хучилттай болгож шинэчлэхээр төлөвлөгдсөнөөс Их Монгол Улсын гудамжны 7508 м.кв явган хүний зам, талбайг шинэчлэх ажил бүрэн дуусаж, Чингисийн өргөн чөлөөний 23400 м.кв явган хүний зам талбайг засварлаж шинэчлэх ажил 70 хувийн гүйцэтгэлтэй он дамжин хэрэгжиж байна.	50%

Хугацаа болоогүй, үнэлэх боломжгүй 1 арга хэмжээ:

Д/д	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Хариуцах нэгж	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
ДЗДҮАХ-ийн зорилго 2.4. Иргэд амарч, тухлах ногоон байгууламж бүхий тохилог орчинг байгуулж, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.				
Зорилт 30. Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх бодлого баримтлан иргэд, сургууль, цэцэрлэг, сууц өмчлөгчдийн холбоодод дэмжлэг үзүүлнэ. (НЗДҮАХ 4.1.4, 4.5.3, 4.5.5, ДЗДҮАХ 2.4.5)				
59	Арга хэмжээ: 30.1 Газарзүй мэдээллийн системд суурилсан ногоон байгууламжийн мэдээллийн санг ашиглалтад оруулна.	ХХҮХ	Дүүргийн хэмжээнд ногоон байгууламжийн судалгаа, мэдээллийн сан хийх ажлын гүйцэтгэгчээр "Говийн улиас" ХХК шалгарч, ажлыг гүйцэтгэж байсан боловч ажлын чанар гүйцэтгэл хангалтгүйгээс 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр гэрээг цуцалсан.	-

ТАВ. ДҮГНЭЛТ

Дүүргийн Засаг даргын 2025 оны Хариуцлагын гэрээний 109 заалт жилийн эцсийн байдлаар 4,5 хувь нь хангалтгүй, 3,6 хувь нь үр дүн хүлээгдэж байгаа бөгөөд 91,7 хувь нь үр дүнтэй хэрэгжсэн байна.

Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 122 арга хэмжээ жилийн эцсийн байдлаар 7,4 хувь нь хангалтгүй 8,1 хувь нь хангалттай, 83,6 хувь нь бүрэн хангалттай хэрэгжиж 0,8 хувь нь хугацаа болоогүй байна.

Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зарим арга хэмжээний зорилтот түвшинг суурь түвшингээс эрс багаар төлөвлөх, зорилт арга хэмжээндээ иргэд олон нийтийг хамарсан олон талт зохион байгуулалтын ажлууд төлөвлөсөн атлаа ганцхан шалгуур үзүүлэлтээр үр дүнг тооцохоор тусгасан зэрэг дутагдлууд нийтлэг ажиглагдлаа. Тухайлбал;

Зорилтот түвшнийг суурь түвшнээс доогуур төлөвлөсөн арга хэмжээнүүд:

Д/д	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин
57.	Арга хэмжээ: 29.1 Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн арчилгааны ажлын хүрээд цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэгүүдэд гоёлын мод бут тарих, цэцгийн мандал байгуулах замаар хослол зохиомж бүхий цэцэрлэгт гудамж, талбайг байгуулна.	Цэцгийн мандал байгуулсан талбай, м.кв	7033	5000
68.	Арга хэмжээ: 37.1 Энгийн хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх, нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээг	Цуглуулж тээвэрлэсэн хогны жин, мян.тн	155,5	120,0

	сайжруулах арга хэмжээ авч ажиллана.			
83.	Арга хэмжээ 46.1 Өсвөр үе, залуучуудын дунд хорт зуршлаас татгалзах уриалга бүхий видео контентын уралдаан зохион байгуулна.	Зохион байгуулсан уралдаан, хамрагдсан сурагчдын тоо	1 удаагийн сургалт, уралдаан 120-оос доошгүй сурагч	1 удаагийн сургалт, уралдаан 100-аас доошгүй сурагч
87.	Арга хэмжээ 48.1 Хотын стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлан таниулах, сургалт арга зүйгээр хангахад чиглэсэн арга хэмжээ авч ажиллана.	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	(хотын стандартыг хангах чиглэлээр 2024 онд 6 төрлийн арга хэмжээг хэрэгжүүлсэн)	2-оос багагүй

Үр дүнг тооцох боломжгүй шалгуур үзүүлэлттэй арга хэмжээнүүд:

Д/д	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин
50.	Арга хэмжээ:22.1 Хүнсний ногоо тариалах, хүлэмжийн аж ахуйг кластер хэлбэрээр хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллана.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	3
51.	Арга хэмжээ:23.1 Дүүргийн нутаг дэвсгэр дэх хээлтэгч, хээлтүүлэгч малыг үзлэг ангилалтад хамруулах, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	-
62.	Арга хэмжээ:32.1 Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник, технологи, ногоон амьдралын хэв маягийн талаар танин мэдүүлэх, зөв дадал хэвшилд сургах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	2	2
70.	Арга хэмжээ:38.2 Хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтарч хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахивар хог хаягдлыг ангилан ялгах чиглэлээр нөлөөллийн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Зохион байгуулсан сургалт, тоо	3	
81	Арга хэмжээ:44.1 Дүүргийн Засаг даргын нэрэмжит олимпиадыг зохион байгуулж, сурагчдын оролцоог нэмэгдүүлнэ.	Зохион байгуулсан олимпиадын тоо	5	-
84.	Арга хэмжээ:46.2 “Ахмадаа дээдэлье” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. (ДИТХ-ын 2024 оны 16 дугаар тогтоол)	Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний тоо	5	2

Шалгуур үзүүлэлтийн дагуу үр дүнг гүйцэт тайлагнаагүй арга хэмжээнүүд:

Д/д	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хариуцах нэгж
60	Арга хэмжээ 30.2 Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэхэд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог хангах чиглэлээр олон талт зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллана.	Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ, м.кв	8.1		ХСТНААХ
66	Арга хэмжээ: 35.1 Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд тавих хяналт шалгалтыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлнэ.	Нөхөн сэргээлт хийсэн байгууллагын тоо	10		ХСТНААХ
100	Арга хэмжээ: 60.1 Дугуйн болон явган хүний замыг стандартад нийцүүлэн өргөтгөн шинэчлэх, шинээр явган хүн, дугуйн замын сүлжээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.	Шинээр ашиглалтад орсон дугуйн зам урт, км	1		ТГУХ

ЗУРГАА. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

1. Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа зорилтот түвшнийг суурь түвшнээс ахиулан бодитой тооцож тусгах,

2. Тухайн арга хэмжээний үр дүнг тооцоход шаардагдах бүх үзүүлэлтийг 1 шалгуур үзүүлэлтээр хязгаарлахгүй, шалгуур үзүүлэлтийн хувилбарууд болон тайлбар, хэмжих нэгжийг оновтой сонгож, зорилтот түвшинг зөвхөн тоогоор илэрхийлэх,

3. Гүйцэтгэлийг тайлагнахдаа хэрэгжүүлсэн бодлого арга хэмжээний тоо баримт, нотлох үзүүлэлтийг нэгтгэн хүрсэн үр дүнг товч тодорхой, эмх цэгцтэй, өмнөх оны мөн үетэй харьцуулж дүгнэн тайлагнах;

4. Тайлант хугацааны явцад тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан төсвийг батлагдсан төсвийн хамт дурдаж, тайлагнах,

5. Дүүргийн Засаг даргын 2025 оны хариуцлагын гэрээ, Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс хангалтгүй буюу үр дүн гараагүй заалт, арга хэмжээний хэрэгжилтийг хариуцсан хэлтэс, нэгж, албан хаагчид идэвх санаачилга гарган биелэлтийг хангах нь зүйтэй.

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ 3.БУЯНТ

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ 4.МӨНХГЭРЭЛ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ
ХАРИУЦСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
МЭРГЭЖИЛТЭН Н.АЛДАРМАА